

ГАДААДЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ОНЦЛОГ

(Америк, Европ, Африкийн орнуудын жишээн дээр)

Ч.Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Эх газрын сэтгүүл зүй, «Арлын» сэтгүүл зүй, чөлөөт, хариуцлагатай хэвлэл, телерадио өргөн нэвтрүүлэг, зохиогчийн нэвтрүүлэг.

Мэдээллийн орон зай даяаршиж буй өнөөгийн нөхцөлд гадаадын орнуудын сэтгүүл зүйд уусан нэгдэх үйл явц идэвхтэй өрнөж байгаа ч өөрийн үндэсний онцлогийг хадгалсан хэвээр буй юм.

Европ, Хойд Америкийн орнууд хэдийгээр өрнөдийн соёлын чиг хандлагатай боловч Ойрх Дорнод, Ази-Номхон далайн бүс нутгийн улсуудын нэг адил өөр хоорондоо нэлээдгүй ялгаатай билээ.

Сэтгүүл зүй нь богино хугацаанд ихээхэн өөрчлөгдөж буй, ОНМХ-ийн тогтолцоонд хувьслын үйл явц эрчимтэй явагдаж буй орнуудын онцгой бүлгийг хуучин социалист хамтын нөхөрлөлийн улсууд, тэдгээрийн дотор ЗХУ-ын орон зай дээр үүссэн орнууд бүрдүүлдэг. Эдгээр оронд өрнөсөн нийгэм-улс төр, эдийн засгийн өөрчлөлтүүд тогтмол

хэвлэл, радио, телевизийн үйл ажиллагаанд зохих нөлөө үзүүлсэн юм.

Шинжлэх ухаан, практикийн агуулгаараа сонирхолтой үйл явц Африк тивийн орнуудын сэтгүүл зүйд явагдаж байна. Олон хэлтэй, нутгийн олон аялгуутай энэ тивд ОНМХ үндэстний эв нэгдлийг хангах, өвөрмөц соёлоо даяршлын нөхцөлд авч үлдэх чухал үүрэг хүлээсэн юм.

Европ, Америкийн сэтгүүл зүйн онцлог

Хэдийгээр Европ, Хойд Америкийн орнуудын ОНМХ соёлын чиг хандлагын хувьд нэг язгууртай боловч практик үйл ажиллагааг нь аваад үзвэл эх газрын болон «арлын» гэсэн онцлог, ялгаа бүхий хоёр чиглэлтэй юм¹. «Арлын» хэмээх чиглэлд судлаачид уламжлал ёсоор Их Британи, АНУ-ыг багтаадаг. Европ, Хойд Америкийн сэтгүүл зүй ийн хоёр хуваагдахын эхлэл XIX-XX зуунд тавигджээ.

Анхандаа сэтгүүл зүй эх газар ч тэр, Англид ч тэр ганц хүний сэтгүүл зүйн уламжлалаар хөгжиж байв. Энэ үед зохиолч, нийтлэлчид ихээхэн нэр

хүндтэй, нөлөөтэй байжээ. Тухайлбал, Английн сэтгүүл зүйг үндэслэгч хэмээх эрхэм алдрын төлөө Жонатан Свифт, Даниэль Дефо, Ричард Стил, Жозеф Аддисон нар өрсөлддөг бөгөөд тэр бүгд зохиолчид байв. Гэхдээ нийгмийн хөгжил, улс төрийн нөхцөл байдлыг даган ОНМХ хувьсаж, улмаар эх газрын Европ, Английн сэтгүүл зүйн хооронд ихээхэн ялгаа гарсан юм.

Эх газрын Европ, Их Британийн сэтгүүл зүй нь өөр хоорондоо ялгаа бүхий роман-герман, англи-сакс эрх зүйн тогтолцооны улс төрийн орон зай дээр хөгжиж иржээ. Үүнд 1830-1840-өөд оны үед «арилжааны хувьсгал»-ын дараа сонины агуулгад өөрчлөлт гарсан Их Британи, АНУ-ын харилцан нөлөөлөл ч багагүй хувь нэмэр оруулсан юм.

Хэрэв эх газрын сэтгүүл зүйд сэтгүүлчийн үзэл бодол, зохиогчийн байр суурьд ихээхэн ач холбогдол өгч байсан бол «арлын» сэтгүүл зүй баримтыг улам бүр чухалчлах болж, олон нийтийн сонирхлыг татсан үйл явдалд онцгой анхаарах болжээ.

Энэхүү ялгаа аажимдаа ноцтой үр дагаварт хүргэсэн юм. Тухайлбал, Герман, Франц, эсвэл Оросод сэтгүүлчид аудиторид нөлөөлөх үр ашигтай арга замыг эрэлхийлж, улмаар бичлэгийн төрөл, зүйлийн онолыг хөгжүүлэх, мэтгэлцээний арга барилыг боловсронгуй болгоход ач холбогдол өгч байв. Тэгвэл АНУ, Их Британид шуурхай байдал, чухал баримт олж авах чадварыг илүү үнэлж байжээ. Энэ нь мэдээллийн шинжтэй материалуудыг «уруугаа харсан пирамид» бүтцээр бичих арга барилыг газар авахад хүргэсэн байна. Үүний үр

дүнд нэгнийх нь хувьд сэтгүүл зүй нь зохиогч уран сайхны зохиогдохуунтай биш, харин бодит үйл явдал, үзэгдэл, хүмүүстэй харьцдаг ерөнхий утга зохиолын ажлын нэг хэсэг болсон бол нөгөөгийх нь хувьд хүлээн авагчид чухал мэдээллийг ОНМХ-ээр түгээх зорилгоор ашигладаг харилцааны нэг суваг болжээ.

ОНМХ-ийн үйл ажиллагааг тайлбарладаг Америк-Британийн хандлагын зарим нэг онцлогийг дурдъя.

Ганнетын «Ньюз-2000» сонины сүлжээний загвар нь харилцааны онолын үндсэн шаардлагуудад нийцдэг. Пирамидын орой нь нийгэмд хүсч буй өөрчлөлтийг авчрахад чиглэгддэг, харин суурь нь олон нийтийн ашиг сонирхол дээр тулгуурладаг. Энэхүү загвар нь аудиторийн бодол санаа, сэтгэл хөдлөлд нөлөөлдөг бүхий л хүчин зүйлийг харгалзан үзсэн байдаг учир олон нийтийн санал бодлыг залах онолтой ч холбоотой.

Хэдийгээр Ганнетын сонинуудын загвар нь юуны түрүүнд америк уншигчдад зориулагдсан боловч тодорхой хэмжээний хувилалтайгаар бусад оронд ч хэрэглэгдэж болдог.

АНУ-д удаан хугацааны турш сэтгүүл зүйн мөн чанарын тухай мэтгэлцээн өрнөж байсан юм. Роберт М. Хатчинсын комиссийн «Чөлөөт, хариуцлагатай хэвлэл» илтгэл нь янз бүрийн улс орны сэтгүүл зүйн онол, практикт маш их нөлөө үзүүлсэн үзэл санааны чухал эх сурвалж болжээ. Хүчин төгөлдөр хууль тогтоомжоос илүүтэйгээр олон нийтийг хамгаалж чадахуйц арга хэмжээ авах замаар тулгамдсан асуудлуудыг шийдэх

саналыг комисс дэвшүүлсэн байна. Үүний тулд чөлөөт, хариуцлагатай хэвлэлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагын таван хэм хэмжээг боловсруулжээ:

- «Өдрийн үйл явдлыг ач холбогдолтой болгохуйц үнэн бодит, олон талт тайлан»-г хангах;

- «Тайлбар, шүүмжлэлийг харилцан солилцох индэр»-ийн үүрэг гүйцэтгэх;

- «Нийгмийг бүрдүүлж буй бүлгийн бүрэн дүүрэн дүр зураг»-ийг өгөх;

- «Нийгмийн зорилго, үнэт зүйл»-ийн тухай мэдээлэх, тэдгээрийг тайлбарлах;

- «Өдрийн мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх боломж»-ийг бүрдүүлэх².

Бичиг үсэгт тайлагдсан хүн бүр сонинд мэдээлэл бичиж чадна, харин хэвлэлд материалаа нийтлүүлэхээ больсон хүн сэтгүүлч байхаа больдог учир сэтгүүл зүй нь бие даасан мэргэжил биш болохыг комисс үүний зэрэгцээ тэмдэглэжээ.

Сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх Америкийн тогтолцоо нь сэтгүүлчийн боловсролыг үндэслэгчдийн нэгд тооцогддог Жозеф Пулитцерээс эх авдаг тул энэ нь олон байр суурины нэг нь л юм. Пулитцерийн гэрээс ёсоор түүний хандивласан мөнгөөр 1904 онд Колумбийн их сургуульд мэргэжлийн сэтгүүлчийн боловсон хүчин бэлтгэх АНУ-д анхны сургууль байгуулагдсан бөгөөд

түүний боловсруулсан журнализмын тандартууд үндсийг нь бүрэлдүүлжээ. Энэ сургуульд боловсон хүчин бэлтгэх асуудлыг Пулитцер гагцхүү суурь мэргэшүүлэлтийн үндсэн дээр л ойлгож байжээ.

Хэвлэлийн эрх чөлөөний язгуур болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах санаа нь зерэг шинжтэй юм. Гэхдээ нийгмийн хариуцлагын номлолын

онолчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөө идэвхтэй тэмцэх төдийгүй, Хатчинсын комиссийн боловсруулсан чөлөөт, хариуцлагатай хэвлэлд тавигдах шаардлагуудыг биелүүлэхийг хэвлэл, засгийн газар, олон нийтээс уриалж байв. Засгийн газар нь хэвлэ-

«

*Хэрэв эх газрын сэтгүүл зүйд
сэтгүүлчийн үзэл бодол,
зохиогчийн байр суурьд ихээхэн
ач холбогдол огч байсан бол
«арлын» сэтгүүл зүй баримтыг
улам бүр чухалчлах болж, олон
нийтийн сонирхлыг татсан
үйл явдалд онцгой анхаарах
болжээ.*

»

лийн чухам үйл ажиллагааг нь хяналгүйгээр түүний үйл ажиллагаа явуулж буй орчныг хянах үүрэгтэй ч, ёстой ч гэж үздэг: «Илүү шударга тоглолтонд зориулж дүрэм, нөхцлийг тогтоох нь тоглогчдын эрх чөлөөг хумиж буй хэрэг огт биш. Харин ч тоглогчдын хувьд ч, үзэгчдийн хувьд ч тоглолтыг сайжруулж буй юм. Энэ байр сууринаас чөлөөт хэвлэлийн бүхий л үйл ажиллагааг үзэх нь хэвлэлийн өөрийнх нь хувьд ч тэр, хүлээн авагчдын хувьд ч тэр адилхан давуу талтай. Ингэхдээ зүй зохисгүй зарцуулалт, эмх замбараагүй байдлыг багасгах, олон нийтийн жинхэнэ үзэл бодлыг бүрэлдүүлэх, дээд зэргийн

чанартай хэвлэлийг аль болох олон тооны хүнд хүргэх зорилт тавигддаг»³.

Хэвлэлийн хариуцлагыг дээшлүүлэхийн тулд засгийн газар юу хийж болох, юу хийх ёстойг Хатчинсын комисс нарийн зааг гарган тогтоосон ч хэвлэл «хариуцлагагүй авирласан» тохиолдолд засгийн газар үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс хутгалдан орж болох магадлалыг сэтгүүлчид, шинжлэх ухааны нийгэмлэгийнхэн эрс зэмлэн хүлээн авсан байна. Нийгмийн хариуцлагын номлол нь хэвлэлийн үйл ажиллагааг хязгаарлах, эрх чөлөөг нь хумих аюултай тухай болгоомжлол ч яригдаж байв. Учир нь хэвлэл хариуцлагагүй байдлын зарим нэг жишээ гаргахгүйгээр, тэр ч байтугай бүхэл бүтэн үе туулалгүйгээр улс оронд чөлөөт хэвлэл оршин тогтнох боломжгүй гэж Хатчинсын номлолыг эсэргүүцэгчид мэдэгджээ. «Нийгмийн хариуцлага»-ын тухай ойлголт нь сэтгүүлчийн үүргийн эх үүсвэр, мөн юуны төлөө чиглүүлэгдэх тухай асуудлыг огт хөндөлгүй тойрон өнгөрснийг Америкийн судлаачид шүүмжилсэн нь үндэслэлтэй байсан юм⁴.

Улмаар ОНМХ-ийн үйл ажиллагаанд засаглал хөндлөнгөөс оролцох аливаа хэлбэр нь ямар ч гэгээлэг зорилготой байснаас үл хамааран мэдээллийн эрх чөлөөнд халгаатай болохыг хэвлэлийг төрийн зүгээс зохицуулах Америкийн туршлага харуулж байна. Нийгмийн өмнө хүлээх сэтгүүл зүйн хариуцлага бол өөрийн зохицуулалтын салбар болохоос биш төрийн зохицуулалтын салбар огт биш юм.

Цахим ОНМХ дэх мэдээллийн урсгалын зохицуулалт нь онцгой салбар билээ. Цахим ОНМХ-ийг зохицуулах

Америк тогтолцооны онцлогийг ерөнхийлж хураасан хэлбэрээр Индиана мужийн их сургуулийн профессор Герберт Терри өгүүлжээ⁵.

АНУ-д радио өргөн нэвтрүүлгийн тухай 1934 оны акт үйлчилдэг. Өнгөрсөн 75 жилийн хугацаанд энэхүү тогтоомжинд олон тооны нэмэлт оруулсан бөгөөд эдгээр нь түүнийг хэлбэрийн хувьд ихээхэн өөрчилж шинэчилсэн байна. Тухайлбал, 1968 онд олон нийтийн радио өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын тухай, 1970 онд кабелийн телевизийн тухай, 1996 онд телефон компани болон компьютерийн сүлжээний тухай нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Цахим ОНМХ-ийн хувьд түүний үйл ажиллагааг хянадаг байгууллага, хувь хүмүүсийн дотор ач холбогдол бүхий нь Мужуудын холбооны комисс, шүүх тогтолцоо, АНУ-ын ерөнхийлөгч, мужуудын захиргаа, түүнчлэн олон улсын гэрээ, хэлэлцээрүүд юм.

Холбооны комисс ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлж, конгресс баталдаг таван гишүүнээс бүрддэг. Холбооны комисс нь өргөн нэвтрүүлэг дамжуулах эрхийн лицензи олгож, үелзлийг хуваарилж, цацалтын журмыг санал болгодог. Холбооны комисс юу хийж болохыг санал болгодог ч өргөн нэвтрүүлэгчид ямар нэг мэдээлэл дамжуулахыг нь хориглох эрхгүй байдаг. АНУ дахь хамгийн том өргөн нэвтрүүлэгчид нь хувийн компаниуд байдаг. Түүхэн хөгжлийн явцад Холбооны комисс өргөн нэвтрүүлэгчдийг төдийгүй, телефон болон цахилгаан мэдээний сүлжээг зохицуулдаг. 1980 оныг хүртэл өргөн нэвтрүүлэгчид нь сонсогч, үзэгчиддээ

мэдээллийн хөтөлбөр санал болгох үүрэгтэй байв. Ингээгүй тохиолдолд өргөн нэвтрүүлэгчдийн лицензийг цуцалдаг байлаа. Энэхүү байдлын талаар янз бүрийн байр суурь удаан хугацааны турш эсрэгцсэний үр дүнд гагцхүү эрүүл өрсөлдөөн л мэдээллийн хөтөлбөрт чухам хэдэн цаг зарцуулахыг тодорхойлох ёстой гэсэн шийдвэрт 1980 онд хүрчээ.

Мужуудын холбооны комиссоос гаргаж буй хууль, тогтоомжуудад шүүх тогтолцоо нөлөөлөх боломжтой. Шүүх нь хуулиудыг, тэдгээрийн дотор Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийг тайлбарлах эрхтэй байдаг.

Хянах, хууль тогтоох санаачилга гаргах эрх бүхий субъект нь ерөнхийлөгч байдаг. Ж.Картерын санаачилгаар арилжааны департаментэд Үндэсний теле харилцааны агентлаг байгуулагдсан нь радио-, теле өргөн нэвтрүүлгийн ерөнхийлөгчийн үндсэн зөвлөхийн үүрэг гүйцэтгэдэг. Чухам энэ байгууллагаар дамжуулан конгресс олон нийтийн ХМХ-д зориулж мөнгө гаргадаг.

Мужуудын захиргаа АНУ-д холбооны улс болохынх нь хувьд ихээхэн бүрэн эрхтэй байдаг учир цахим ОНМХ-д идэвхтэй нөлөөлдөг.

Олон улсын гэрээ, хэлэлцээр нь гол төлөв үелзэл, харилцааны хиймэл дагуул болон Интернетийн ашиглалт зэргийг зохицуулдаг. АНУ, Канад, Мексикийг нэгтгэдэг Хойд Америкийн чөлөөт худалдааны ассоциаци нь нөлөө бүхий байгууллага юм. АНУ, Канад дахь фирмүүдийн рекламыг хязгаарлах оролдлогыг Канадын засгийн газар хийсэн нь АНУ-д ихээхэн

бухимдал, зэвүүцлийг төрүүлжээ. Чухамдаа Хойд Америкийн чөлөөт худалдааны ассоциаци нь цахим ОНМХ дэх реклам асуудлаарх байр сууриа Канад өөрчлөхөд нөлөөлсөн байна.

Цахим ОНМХ-ийг зохицуулах практик нь нарийн дэгжүүлэгдсэн улс төрийн мэтгэлцээний хувьд илүү тод мэдрэгддэг. Түүнээс гадна ажлын өдрийн нэг цагийн нэвтрүүлэгт 12 минутаар, амралтын өдрийн нэг цагийн нэвтрүүлэгт 10,5 минутаар хязгаарлагдсан хүүхдийн өргөн нэвтрүүлгийн хуулиуд байдаг. Б.Клинтонь санаачилгаар, сайн дурын үндсэн дээр өргөн нэвтрүүлгийн ихэнх компани долоо хоногт гурван удаа гурван цагаар хүүхдүүдэд зориулсан нэвтрүүлэг цацахаар тогтсон байна. 1996 оны теле харилцааны актын дагуу теле өргөн нэвтрүүлгийн бүхий л компани хүүхдүүдэд зориулагдаагүй секс, хүчирхийллийн дүрсийг телевизорт унтраадаг «ви-чип» хэмээх тусгай код боловсруулах үүрэг хүлээжээ. Түүнчлэн доромжлол болон зохисгүй нэвтрүүлгийг хязгаарладаг төхөөрөмжийг Мужуудын холбооны комиссоос тогтоосон байдаг. Сүүлийн жилүүдэд энэ асуудлаар хянагчдын анхаарлыг радио ихээр татаж байна.

XX зууны сүүлийн 10 жилд цахим ОНМХ-ийн салбар дахь монополийн эсрэг хууль тогтоомж нь ихээхэн либеральчлагджээ. 1996 онд мужуудын төвшний ихэнх хязгаарлалтыг цуцалсан боловч зарим нэг нь орон нутгийн төвшинд үлдсэн байна. Тухайлбал, нэг эзэмшигч нийгмийн нэг давхаргад чиглэгдсэн станциудын 50-иас илүү хувийг эзэмших эрхгүй. Телевизийн

сүлжээний эзэмшигч тухайн газар нутаг дахь үзэгчдийн 35-аас илүүгүй хувийг үйлчлэх эрхгүй бөгөөд нийгмийн нэг давхаргад чиглэгдсэн нэг л станцийг эзэмшинэ (1996 оныг хүртэл хоёр станцийг эзэмшиж болдог байсан). Өнөөдөр АНУ-д кабелийн телевиз илүү эрчимтэй хөгжиж байгаа нь хиймэл дагуулын телевиз хурдан дэлгэрэх боломжийг хааж буй юм. 1996 оны акт нь кабелийн телевизийн үнийн бодлогод ихээхэн анхаарал хандуулжээ. Монополийн эсрэг хязгаарлалтыг цуцалсан нь АНУ дахь ноцтой өрсөлдөөний тухай яриаг үндэслэлгүй болгосон юм. Тухайлбал, Ай-ти-ти кабелийн томоохон сүлжээ Ти-си-айг эзэмших болсон нь өргөн нэвтрүүлгийн бас нэг монопол үүсэхэд хүргэжээ.

1996 оны акт нь Интернеттэй холбоотой асуудлуудыг зохицуулахад чиглэгдсэн харилцааны практикийн хэсэгтэй.

Эх газар-Европын туршлага нь илүү олон талт юм. Учир нь Европт ОНМХ-ийн өмчлөлийн хэлбэр нь Америкийнхаас илүү баялаг байдаг. Олон оронд ОНМХ-ийн талаар төрийн баримталж буй байр суурь ихээхэн хатуу байдаг ч нөгөөтэйгүүр үг хэлэх, хэвлэн нийтлэх жинхэнэ эрх чөлөөг хангахын тулд чамгүй зүйл хийгдэж байгаа.

Тухайлбал, Европын Зөвлөлийн Парламентын Ассамблейн нэгдүгээр ээлжит хуралдаан нь (1970 оны 1-р сарын 23) «Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон хүний эрхийн тунхаг»-ийг баталжээ. Хэвлэл болон олон нийтийн мэдээллийн бусад хэрэгслийн хариуцлагыг хангах талаар авах арга хэмжээг уг

тунхагийн тусгай хэсэгт авч үзсэн байдаг. Нийгэм, иргэдийн өмнө хүлээж буй хариуцлагаа сэтгүүлч ухамсарлан ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд тэдний мэргэжлийн бэлтгэлийг зохих төвшинд гүйцэтгэж, мэргэжлийн ёс зүйн зарчмыг батлан мөрдүүлж, өөрийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий хэвлэлийн асуудлаарх зөвлөлийг байгуулах хэрэгтэй гэж үзжээ.

1996 онд энэхүү баримт бичгийг Оросын парламент соёрхон баталсан бөгөөд үүний дараа л Европын Зөвлөл тус улсыг эгнээндээ элсүүлсэн байна. Үүний дараа Оросын сэтгүүлчдийн өмнө тулгарсан нэг асуудал бол өөрийн зохицуулалтын салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн нэр төдий шинжийг гэтлэх явдал байлаа. Тухайлбал, ёс зүйн зарчмуудын үр нөлөөг дээшлүүлэх, мөн сэтгүүлчдийн байгуулсан ёс зүйн хороодын нэр хүндийг бэхжүүлэх шаардлагатай тулгарчээ. Сүүлийн жилүүдэд Оросод сэтгүүлчдийн ёс зүйн асуудлыг хэлэлцэх эрх бүхий хороо байгуулах оролдлого хэд хэд хийгдсэн ч төдийлөн үр дүнд хүрээгүй байна.

ОНМХ-ийн үйл ажиллагааны Европ-эх газрын болон «арлын» хэлбэр нь олон байр суурь, хандлагатай бөгөөд хоёр уламжлалыг хослуулсан нь ч бий. Үүний жишээ бол Хойд Европын орнуудын сэтгүүл зүй юм. Энэ бүсийн улсуудад АНУ, Их Британийн нэг адил мэдээ, баримтад тэргүүлэх зэргийн ач холбогдол өгдөг. Гэхдээ «уруугаа харсан пирамид»-ын зарчим тэр бүр мөрдөгддөггүй, сэтгүүлч нууц нэрээр бичих нь өдрийн од шиг ховор ажээ. Түүнээс гадна Шведийн «Свенска дагбладет»

сонин бүхий л материалаа зохиогчийн нэртэй төдийгүй, цахим шуудангийн хаягтай нь нийтэлдэг. Ингэснээр тус сонин уншигчдад сэтгүүлчээс нэмэлт мэдээлэл авах, зарим зүйлийг тодруулах боломж олгодог. Скандинавын хэвлэлүүд хэдийгээр рекламьг мэдээллээс зааглах зарчмыг баримталдаг ч далд тайлбар, шуурхай тайлбарыг байж болох зүйл гэж үздэг.

Цахим ОНМХ-ийн үйл ажиллагааг төрийн зохицуулалтаас илүүтэйгээр нийгэм-эрх зүйн болон зах зээлийн механизм зохицуулдаг байна⁶.

Европын орнуудын туршлага нь мэдээллийн бодлогод гаднаас ямар нэг дарамт үзүүлдэг байдлыг бүрэн үгүй хийсэн теле-, радио өргөн нэвтрүүлгийн сонгодог хэлбэрийг олсон болохыг харуулдаг. Энэ хэлбэр бол олон нийтийн өргөн нэвтрүүлэг юм. Ийм теле-, радио өргөн нэвтрүүлэг байгуулах арга замыг олон нийтийн мэдээлэл, харилцааны салбар дахь бодлогын сайд нар оролцсон олон улсын дөрөвдүгээр бага хурлын «Олон нийтийн теле-, радио өргөн нэвтрүүлгийн ирээдүй» хэмээх Нэгдүгээр тогтоолд дурдсан байдаг (1994 оны 12-р сарын 7-8, Прага). Европын Зөвлөлийн гишүүн бүр эрт орой нэг цагт теле-, радио өргөн нэвтрүүлгийн энэхүү загварыг хүлээн авах үүрэгтэй.

Дорнод, Төв Европын орнууд, мөн хуучин ЗХУ-ын буурин дээр бий болсон улсууд онцгой бүлгийг бүрдүүлдэг. Сүүлийн жилүүдэд эдгээр оронд ОНМХ-ийн агуулгад ч, мэдээллийн урсгалыг зохицуулах хэлбэр, аргад ч чухал өөрчлөлтүүд гарчээ. Юуны түрүүнд ОНМХ-

ийг төрийн мэдлээс гаргах, нийтлэл, нэвтрүүлгийн агуулгыг чанаржуулах тал дээр ихээхэн зүйл хийгдсэнээс гадна үндэсний сэтгүүл зүйд Барууны стандартуудыг нэвтрүүлэх үйл явц эрчимтэй явагдаж байна.

АНУ, Европын орнуудын ОНМХ-ийн тогтолцоонд ажиглагдаж буй шинэлэг хандлага нь ажил хэргийн болон шуурхай мэдээлэл компьютерийн сүлжээ рүү «нүүсэн», задлан шинжилсэн, тайлбарласан, хэтийн төлөвийг гаргасан материалын эзлэх жин нэмэгдсэн, радио, телевиз дэх зохиогчийн нэвтрүүлгийн үнэ цэнэ, ач холбогдол өссөн зэргээр илэрч буй юм.

Африкийн орнуудын сэтгүүл зүйн онцлог

Африкийн орнуудын ОНМХ хөгжлийн хүнд бэрх үеийг туулж байна. XX зууны 2-р хагас тус тивийн хувьд үйл явдлаар нэн өрнүүн үе байсан юм. Колоничлолын тогтолцоо задран унасан, дөнгөж үүссэн тусгаар улсууд бэхжин хөгжсөн, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, бодлогын үүр болсон Өмнөд Родези, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс дахь засгийн эрх хар олонхийн гарт орсон, олон тооны иргэний дайн дэгдсэн явдал нь үндэсний хөгжлийн чиг баримжааг сонгоход ямар нэг байдлаар нөлөөлж байжээ. Барууныг баримтлагч зах зээлийн эдийн засагтай улсууд удаан хугацааны турш социалист чиг баримжаатай орнуудтай зэрэгцэн оршиж байсан ба хөгжлийн замын сонголтоос үндэсний ОНМХ-ийн тогтолцооны төлөвшлийн онцлог ихээхэн шалтгаалж байв.

Дэлхий дахинаа өрнөж буй улс төрийн нарийн төвөгтэй үйл явц нь Африк тив, Африкийн ОНМХ-ийн байдалд зохих нөлөө үзүүлсэн юм.

Африк тив нь Хойд ба Өмнөд, Өрнө ба Дорно зүгийн хурц зөрчлийн дунд оршдог. Үүнд шашны ялгаа, түүнчлэн Европын гүрнүүдийн колоничлол ихээхэн нөлөөлжээ. Шон Макбрайдын комисс хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хоорондох ангал нэн гүн болсныг тодорхой жишээ баримтаар харуулсан юм. Үүнээс гарах арга зам бол мэдээлэл, харилцааны олон улсын шинэ дэг журам тогтоож, социалист нийгэм байгуулах чигийг баримтлах явдал мөн гэж Африкийн орнуудын улс төрийн олонх зүтгэлтэн үзэж байжээ. Харамсалтай нь эдгээр чиг нь хүршгүй, биелэгдэшгүй байв. Социалист системтэй цуг мэдээлэл, харилцааны олон улсын шинэ дэг журам тогтоох горьдлого ч нуран унажээ. Үүний нэг сөрөг үр дагавар нь баян, ядуугийн ялгаа улам их нэмэгдсэн явдал байлаа.

Байдал ийн эргэж болохыг судлаачид урьдчилан хэлж байжээ. Тухайлбал, Розалинд Эйнсли 1966 онд хэвлэгдсэн «Африкийн хэвлэл» хэмээх судалгааны ажилдаа: «Эдийн засгийг хөгжүүлэх “шийдвэртэй” хөтөлбөр хэрэгжүүлэхдээ ОНМХ-ийг багаж болгон ашиглах зорилго тавьсан засгийн газрууд хүлээцтэй хандахын оронд арилжааны өрсөлдөгч хэвлэлд үл тэвчих хандлагатай гаргах магадлал өндөр байна. Ялангуяа ийм хэвлэл гадаад эзэдтэй бол энэхүү хандлага бүр ч хүчтэй мэдрэгдэнэ. Социалист чиг баримжаатай орнуудад хувиараа аж ахуй эрхлэх явдал, мөн арилжааны реклам нь улс төртэй зөрчилтэй

байдаг нь асуудлыг хурцатгаж буй юм. Хэрэв өдгөө гадаадын пүүс компаниудтай өрсөлдөхөд хүнд байгаа бол ирээдүйд бүр ч бүтэшгүй зүйл болно. Өнөөдөр бид даян дэлхийд хэвлэлийн ажилд хувьсгалт өөрчлөлт авчирсан техникийн үсрэнгүй хөгжлийн босгон дээр зогсож байна. Офсет машинууд суурь болон урсгал зардлыг эрс багасгах боломж олгож эхэллээ. Дэлхийн хиймэл дагуулуудын тусламжтайгаар дүрс дамжуулах нь эцсийн эцэст хямд, амар хялбар болно. Харин тэдгээрийн тусламжтайгаар сонины бүхэл бүтэн нүүрүүдийг дамжуулах боломж өнөөдөр бодит зүйл болоод байна. Африкийн хувьд энэхүү дэвшлийг нэвтрүүлэх нь орон нутгийн хэвлэлийг богино хугацаанд эрчимтэй хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх юм. Гэхдээ олон улсын томоохон компаниуд хөгжиж буй орнуудын хэвлэлийг Парис, Лондон, эсвэл Нью-Йоркт хэвлэгдэж буй сонинуудын орон нутгийн хувилбар болгох аюултай. Африк тив одоо л сонголтоо хийх хэрэгтэй санагдана. “Нийтийн хэрэглэний салбар” болохынх нь хувьд ОНМХ-д хөрөнгө оруулах, эсвэл энэ салбарт гадаадын ноёрхол зайлшгүй тогтоно гэдэгтэй эвлэрэхээ шийдэх цаг болжээ”⁷.

Я мартаа ч колоничлолын тогтолцоо задран унасны дараа хар тивийн үндэсний хэвлэл асар их саад бэрхшээлийг туулан хөгжиж байна. Чөлөөт ОНМХ төлөвшин тогтох хэцүүхэн үйл явцад улс төрийн тогтворгүй байдал саад учруулж, энэ нь эргээд шинэ тутам байгуулагдсан орнуудын эдийн засаг, улс төр, үзэл сурталд сөргөөр нөлөөлжээ. Хуучин метрополиуд «үл оролцох»

бодлого баримтлах болсон нь ОНМХ-ийн тогтолцооны үүсэл, хөгжил, төлөвлөлийн үеийг туулж өнгөрүүлсэн өөрсдийн зүгээс техник технологи болон боловсон хүчнээр туслах явдлыг хааж боогдуулсан юм.

Африк тивд сэтгүүл зүй хөгжихөд саад учруулж буй хоёр хүчин зүйл бол бичиг үсэгт тайлагдаагүй хүмүүсийн эзлэх хувь өндөр, мөн олон хэлтэй (Африкийн 53 орны 1 тэрбум хүн 2125 хэлээр ярьдаг) явдал билээ. ЮНЕСКО-гоос эрхлэн гаргадаг «Курьер» сэтгүүл 1988 оны 8-р сарын дугаартаа Африкийн хөдөөний хэвлэлийн байдлын тухай ийн өгүүлсэн байдаг: «Өнөөдөр Африкт 1000 хүний 15 нь л өдөр тутмын сонин авах боломжтой. Сониныг ОНМХ-ийн хувиар ашиглах нь хүн амын 80 хувь аж төрж буй, 800 хэлээр ярьдаг хөдөө аж ахуйн бүсэд ихээхэн хүндрэлтэй тулгарч байна. Гэхдээ хэвлэл нь хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд бүрэн дүүрэн оролцоход тусгаарлагдмал, салангид хөдөөний оршин суугчдад саад учруулж буй мэдээлэл харилцааны хоосон орон зайг нөхөж, түүнчлэн бичиг үсэгт суралцахад чанартай нэмэлт материал болж буй юм. Энэ салбарт ЮНЕСКО хөдөөний сонин байгуулах, сэтгүүлчийг сурган бэлтгэх, тоног төхөөрөмж нийлүүлэх замаар олон жилийн турш гишүүн орнуудтай хамтран ажиллаж байна. Одоо хэрэгжүүлж буй нэг арга хэмжээ бол Котонуд (Бенин) байрладаг, үндэсний 13 агентлагийг хамарсан, Баруун болон Төв Африкт мэдээллийн агентлаг хөгжүүлэх төсөл (WANAD) юм. Үүнтэй ижил төстэй төслийг (SAENAD) 1986 оноос Африкийн өмнөд,

дорнод хэсэгт хэрэгжүүлж эхлээд байна».

Дэлхийн янз бүрийн оронд төлөвшсөн ардчиллын загварыг Африкийн нөхцөлд туршдаг лаборатори маягаар Бениныг олон судлаач үзэж байв. Учир нь авторитар дэглэмээс ардчилсан тогтолцоо руу шилжих үйл явц Бенинд Африкийн бусад орныг бодвол ОНМХ-ийн санаачилгаар явагджээ. В.Н. Шиловын тэмдэглэснээр: «Ардчилалжих үзэл санаа энэ улсад анхандаа хэвлэлээр (юуны түрүүнд чөлөөт) дамжин нийгэмд идэвхтэй сурталчлагдаж, мэтгэлцээн өрнүүлсэн бөгөөд үүний дараа л олон нийтийн байгууллага, засаглалын бүтцэд нэвтрүүлэх асуудал яригдаж, оролдлого хийгдсэн байв»⁸.

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын ялгарал улам нэмэгдэж буй тухай дээр өгүүлсэн. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн мэргэжилтнүүд дундаж нас, боловсролын төвшин, нэг хүнд ногдох орлого гэсэн гурван хүчин зүйлийг харгалзаж Хүний хөгжлийн индексг боловсруулсан байдаг. Энэ хэмжүүрээр гаргасан хүснэгтэд дэлхийн 182 орны сүүлийн 24 байрын 22-ыг Африкийн орнууд эзэлжээ (энэ хүснэгтэнд Монгол 115-д жагсчээ).

Дэлхийн хэмжээнд ярилтгүйгээр Африкийн орнуудын хооронд ч эрс тэс ялгаа бий. Тухайлбал, Нигери, ӨАБНУ хоёр нийлээд тивийнхээ үндэсний нийт бүтээгдэхүүний бараг талыг үйлдвэрлэдэг. Хүн амд ногдох орлогын хэмжээг нэмэгдүүлж, инфляцийг бууруулах зорилгоор Африкийн олон орон 1990-ээд оноос эдийн засаг, бүтцийн томоохон шинэтгэл хийж эхэлжээ. Анхны үр дүн

1990-ээд оны дундуур мэдрэгдсэн байна. Эдийн засгийн байдал ч сайжирчээ. Тухайн үед хар тив дээр оршиж байсан 48 орны 40-ийнх нь хүн амын орлого нэмэгдсэн байна. 1994 онд 60%-тай байсан инфляци 1998 онд 10% болж буурчээ⁹. Гэсэн хэдий ч Африк тивд ядуурал гамшгийн хэмжээнд, харин хөрөнгө оруулалт хангалтгүй төвшинд байгаа бөгөөд ихэнх орон урьдын адил гадаадын зээл, тусламжаас ихээхэн хараат байна. Ядууралтай хийх тэмцэлд ямар нэг мэдэгдэхүйц амжилтанд хүрэхийн тулд, тухайлбал, өнөөгийн хөгжингүй орнуудын нэг хүнд ногдох орлогын талд нь хүрэхийн тулд Африкийн хүн амын орлого жил бүр 8-9-өөс доошгүй хувиар өсч байх хэрэгтэй.

Африкт гарч буй нийгэм-улс төрийн өөрчлөлтүүд дэлхий нийтийн чиг хандлагаас ангид байгаагүй юм. Дээр дурдсан Бениний сэтгүүл зүйн үйл ажиллагаанд 1990-1991 онд гарсан өөрчлөлт нь цаг хугацааны хувьд үг хэлэх, хэвлэн нийтлэх бодит эрх чөлөөг тунхагласан Дорнод, Төв Европт өрнөсөн хувьсал, шинэтгэлийн үйл явцтай давхацжээ. Энэ үед Бенинд үүссэн нөхцөл байдлыг судлаач Алексис Ньянгенон: «1990-1991 онд Бенинд өрнөсөн улс төрийн өөрчлөлт шинэтгэл нь ОНМХ үйл ажиллагаагаа чөлөөтэй

явуулах урьдач нөхцлийг бүрдүүлсэн юм. Хөгжлийнхөө чанарын шинэ үед орсон Бениний улс төр, нийгмийн амьдралд гүн гүнзгий өөрчлөлт гарчээ. Ийм нөхцөлд ОНМХ-ийн ажилтнуудын өмнө хүнд бэрх асуудлууд тулгарсан байна. Тэдний нэг хэсэг нь олон арван жилийн турш төрийн албан хаагчид шиг ажиллаж, зөвхөн дээрээс ирсэн үүрэг, даалгаврыг гүйцэтгэж сурсан байв.

Нөгөө хэсэг нь сэтгүүл зүйг бие даасан институт гэдэгт итгэх итгэлээ алдаж, идэвх санаачилгатай ажиллах чадвараа гээсэн байлаа. Бусад нь өмнөх төрийн эрх баригчдийн эсрэг тодорхой хугацаанд гэрээгээр нууцаар ажиллаж байсан учир улс төрөөс ангид, чөлөөт, бие даасан сэтгүүл зүйд дасаагүй байв»¹⁰ гэж дүрсэлсэн байдаг.

«

*Африкт гарч буй нийгэм-улс
төрийн өөрчлөлтүүд дэлхий
нийтийн чиг хандлагаас ангид
байгаагүй юм. Дээр дурдсан
Бениний сэтгүүл зүйн үйл
ажиллагаанд 1990-1991 онд гарсан
өөрчлөлт нь цаг хугацааны хувьд үг
хэлэх, хэвлэн нийтлэх бодит эрх
чөлөөг тунхагласан Дорнод, Төв
Европт өрнөсөн хувьсал,
шинэтгэлийн үйл явцтай
давхацжээ.*

»

Тусгаар тогтносон Бенин улсад 1960 онд хэвлэлийн тухай хууль батлагдсаны дараа нийгэм-улс төрийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарчээ. Хэвлэлийн салбарт төр 30 жилийн турш монополь эрхтэй байсны эцэст 1990-ээд оны эхээр хараат бус сонинууд уншигчдын гар дээр очсон байна. «Газет дю гольф», «Там-там экспресс» зэрэг хараат бус хэвлэл хөдөлмөрчид, залуучуудын улс төрийн идэвхийг дээшлүүлэх, улс төрийн шинэ бүтцийг бүрэлдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй, Бениний нийгэм-

улс төрийн амьдралд ихээхэн нөлөө үзүүлжээ. Хэвлэлийн тухай шинэ хуулиар иргэн бүр зохих газарт нь бүртгүүлснээр ямар нэг саадгүйгээр ОНМХ эзэмших эрхтэй болжээ. Уг хуульд: «Хэвлэлийн эрх чөлөө бол юуны түрүүнд мэдээлэл үйлдвэрлэх болон тэрхүү мэдээллийг түгээх эрх чөлөө мөн тул төр нь хэвлэлийн газар, хэвлэх үйлдвэрүүдийг монополичлох эрхгүй» гэж заасан байдаг.

Хэдий тийм ч өнгөрсөн жилүүдийн сөрөг үр дагавартай холбоотой хүндрэл бэрхшээл байсаар байна. Тухайлбал, мөн хуулийн боловсронгуй бус байдлыг далимдуулж төрийн байгууллагын албан хаагчид сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс янз бүрийн шалтгаар татгалзах тохиолдол цөөнгүй ажээ.

Хэвлэлийн тухай хуультай байх нь улс төрийн эрх чөлөө үгүйгээр хүмүүний оюуны санааг чөлөөтэй түгээх баталгаа болж чадахгүйг тусгаар тогтносон Бениний хэвлэлийн түүх бэлхнээ харуулж байна. Энэ нь хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн язгуур санаа болсон үнэт зүйлийг гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын төлөөлөгчид хэрхэн дагаж мөрдөхөөс шалтгаална гэсэн үг юм. Урьд өмнө хэвлэл төрийн ашиг сонирхолд үйлчлэх ёстой гэж засгийн эрх баригчид үзэж байв. Харин өнөөдөр ардчилах үйл явц, түүний эргэлт буцалтгүй шинж чанарыг бэхжүүлэхэд чөлөөт сэтгүүл зүйн үйл ажиллагаа нэн чухал үүрэг гүйцэтгэхийг тэд ухамсарлан ойлгох болжээ. Хэвлэлийн эрх чөлөөнд эрх мэдэлтнүүдийн зүгээс халдсан тохиолдлууд ихэвчлэн ардчилсан чөлөөт сэтгүүл зүйн туршлагагүйгээс үүдэн

гардаг байна. Бенинд чөлөөт сэтгүүл зүй бэхжин хөгжих хирээр түүнд хандах олон нийтийн хандлагад ч эерэг өөрчлөлт гарч буй юм.

Африк тивийнхэн маш олон хэлээр ярьдаг нь сэтгүүл зүй хөгжихөд чөдөр тушаа болдог тухай дурдсан билээ. Ийм нөхцөлд колоничилж байсан гүрний хэл үндэстэн хоорондын харилцааны хэлний үүрэг гүйцэтгэдэг. Гэвч хүн амын дийлэнх хэсэг нь бичиг үсэгт тайлагдаагүйн улмаас гадаад хэл ашиглаж тэр бүр чаддаггүй. Хүний оюун санааг тээгч гол хэрэгсэл болохынхоо хувьд хэл нь мэдээлэл харилцааны салшгүй нэг хэсэг болдог. Мэдээллийн үйл явцад хүн амын янз бүрийн давхарга татагдан орох нь иргэдийн соёлын төвшин дээшлэх явдалтай шууд холбоотой юм.

Мэдээллийн солилцооны явц нь зөвхөн мэдээлэл боловсруулах, түүнийг түгээхээр хязгаарлагдахгүй. Мөн тэрхүү мэдээллийг ойлгох нь чухал. Үүний тулд мэдээлэл түгээгч, хүлээн авагчийн хувьд нэг үг нэг л утгаар ойлгогдож байх хэрэгтэй. Тэгвэл Африкийн нэлээдгүй оронд ОНМХ-ийн хэл гол төлөв сэхээтний давхаргад л ойлгомжтой байдаг. Африкийн зарим уугуул хэлд ардчилсан сэргэлт, олон намын тогтолцоо, эрх зүйт төр, эдийн засгийг шинэчлэх, хувьчлал, эдийн засгийн хямралаас гарах хөтөлбөр, эдийн засгийн хөгжлийн түншүүд, гадаадын хөрөнгө оруулагчид, үг хэлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, хүний эрх зэрэг ойлголт, томъёолол байдаггүй байна. ОНМХ-ийн нийгэм-улс төрийн үгийн санг утга, агуулгынх нь хувьд задлан шинжлэхэд нутгийн хэлнүүдийн

үгийн сан нийгэм-улс төрийн амьдралын бодит байдлаас хол хоцорсон болох нь харагддаг¹¹. Тиймээс зарим ойлголтыг нутгийн хэл рүү хөрвүүлэхэд тэрхүү хэлийг тээгчид ойлгодоггүй, эсвэл ташаа ойлгох зэрэг хүндрэл учирдаг. Энэ хүндрэлийг гэтлэхийн тулд эсвэл нутгийн хэлийг боловсронгуй болгох, эсвэл колоничлогч гүрний хэл рүү шилжих шаардлагатай юм. Хоёр дахь замыг Хар буюу Сахаараас өмнө тийшх Африкийн олонх орон сонгоод байна.

Африкийн орнуудад мэдээлэл харилцааны үйл явц ардчилах нь хүн амын бичиг үсэгт тайлагдаагүй байдлыг арилгахаас ихээхэн шалтгаална. Хүүхдүүдийг сургуульд 100 хувь хамруулан сургах бодлого Африкийн ихэнх оронд 1990-ээд оноос өмнө хэрэгжиж эхэлжээ. Энэ бол өсвөр насныхан, залуучуудын бичиг үсэггүй байдлыг аажимдаа арилгахад, цаашлаад болзолт уншигчдын тоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодитой бодлого байсан юм. Харамсалтай нь нэлээдгүй оронд боловсролын бодлогыг хөрөнгө мөнгөний асуудлаас болж хумисан байна.

Хэлний тархай болон бичиг үсэгт тайлагдаагүй байдлаас гадна хэвлэл түгэн дэлгэрэхэд саад учруулж буй өөр нэг хүчин зүйл бол сонин унших туршлага үгүй явдал юм. Африкийн уугуул үндэстнүүд аман соёл иргэншилтэй учир бичгийн соёл иргэншил бүхий ард түмнүүдийг бодвол уншихаасаа илүүтэйгээр хуучлах сонирхолтой байдаг. Бичиг үсэгт тайлагдсан, сонин, сэтгүүл худалдаж авах санхүүгийн боломжтой ч олон хүн ийм үйлдэл хийдэггүй байна. Учир нь тэд хэвлэл

унших нь түшмэлийн ажил гэсэн ойлголттой явдаг.

Африкийн орнуудад өрнөсөн зах зээлийн өөрчлөлт, шинэчлэлтийн нөхцөлд ОНМХ оршин тогтнох нь ширүүн өрсөлдөөн, зах зээлийн онцлогоос шалтгаалж хүнд бэрх асуудал болоод байгаа юм. Техникийн хангамж, боловсон хүчний хүрэлцээнээс гадна ОНМХ-ийн маркетинг, менежментийн мэдлэг хангалттай төвшинд хүрээгүй байна. Ийм нөхцөлд богино хугацаанд хэвлэл мэдээллийн олон хэрэгсэл үйл ажиллагаагаа зогсоход хүрдэг. Харамсалтай нь тэдгээр сонин, сэтгүүлийн орыг залгаж шинээр хэвлэл үүсэх боломж тун муу байдаг. Учир нь хэвлэл тэргүүн зэргийн хэрэгцээт бараа биш бөгөөд гагцхүү харьцангуй өндөр орлоготой хүмүүс л худалдан авдаг. Тийм болохоор нэгэнт эзлэгдсэн зах зээлийг дахин хуваахаар хэвлэл эрхлэн гаргах нь ихээхэн хөрөнгө шаардсан, бас эрсдэл дагуулсан алхам болдог.

Хэвлэлийн өртөг өндөр байдаг нь сонин, сэтгүүл эрхлэн гаргахтай холбоотой бүхий л бүтээгдэхүүнийг гадаадаас импортолдогтой холбоотой. Ихэнх хэвлэл цөөн хувиар гардаг учир нэгж ширхгийн өртгийг бууруулах боломжийг хааж буй юм. Дээр нь реклам олгох сонирхолтой, санхүүгийн боломжтой байгууллага цөөн байдаг нь хэвлэлийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Африкийн нөхцөлд хамгийн хүртээмжтэй мэдээллийн хэрэгсэл бол радио юм. Үүнд мэдээллийг сонсдог эртний аман уламжлал нөлөөлдгөөс гадна байнга худалдаж авах шаардлагатай хэвлэл, эсвэл үнэтэй телевизорыг

бодвол радио хүлээн авагч нь хямд төсөр хэрэгсэл ажээ.

Телевизор нь Хар Африкийн олонх оронд мэдээлэл харилцааны элитийн хэрэгсэлд тооцогддог. Радиог бодвол теле өргөн нэвтрүүлэг дамжуулах төв байгуулах нь маш их хөрөнгө оруулалт шаарддаг, дээр нь телевизорыг айл бүр худалдан авах чадваргүй.

Африкийн орнуудын нийгэм-улс төрийн амьдралд сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг хэр бэхжих нь түүний эрх зүйн орчинг сайжруулахтай шууд холбоотой. Сэтгүүл зүй нь «дөрөв дэх засаглал»-ынхаа үүргийг чанарын өндөр төвшинд гүйцэтгэж чадвал нийгэм-улс төрийн салбарт дэвшилтэт өөрчлөлт гарах юм. ЗХУ задран унаж, хуучин социалист орнууд зах зээлийн харилцаанд шилжсэний дараа хар тивийн олонх орон социализмд хандах хандлагаа эргэн харж, энэ нь уг улс төрийн тогтолцоотой холбоотой бүхий л үнэт зүйл өөрчлөгдөхөд хүргэжээ. «Улс түмний эв нэгдэл»-ийг хангахын тулд үндэсний хэл дээр сургалт явуулдаг сургуулиудыг хааж, сонин, сэтгүүл, радио, телевиз Европын орнуудын хэл рүү шилжсэн байна.

Ийм шийдвэрийг төр ОНМХ-ийн заавраар хийсэн гэж Дорнод Африкийн хэвлэлийг судлаач Абубакар Шейх Ражаб дүгнэсэн байдаг. Тус бүс дэх байдлыг тэрээр: «Нийгэм дэх ардчилсан өөрчлөлтүүд ямагт зохион байгуулалтын хувьд төрөөс хараат бус сонин, сэтгүүл, радио, телевиз үүсэхэд хүргэдэг. Гэтэл хүн амын өргөн хүрээний оюун санааг залуурдахын тулд тэдгээрийг ашиглах хүсэл нийгэм, улс төрийн тодорхой хүчнүүдэд төрдөг нь ардчиллын үнэт

зүйлд занал учруулдаг. Үг хэлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг тунхагласан хууль тогтоомжууд батлагдсан байдаг ч мэдээлэл хүлээн авах, түүнийг ашиглах эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд ихээхэн саад барцадтай учирдаг... Дорнод Африкийн орнуудад хэвлэл, төр хоёр хурцадмал байдалд оршдог бөгөөд хууль зөрчсөн, мэдээлэл гуйвуулсан, нийгмийн эмх замбараагүй байдал зохион байгуулсан хэрэгт бие биенээ харилцан буруутгадаг. Төрийн зүтгэлтнүүдийн алдааг илчлэх, тэднийг шүүмжлэх нь одоо ч аюултай хэвээр байна. Үүний зэрэгцээ ОНМХ-ийг хяналтандаа авахын төлөөх тэмцэл хүч авч, хариуцлагатай сэтгүүл зүйн талаарх мэтгэлцээн хаа сайгүй өрнөж, ОНМХ-д ямар хязгаарлалт тохож болох тухай маргалдаж байгаа юм. Нөгөөтэйгүүр хувийн эзэмшлийн ОНМХ-үүд үйл явдлыг (тэдгээрийн дотор улс төрийн) тусгах эрх чөлөөг тууштай хамгаалж байна»¹² гэж өгүүлжээ.

Тивийн олон орныг хамарсан эдийн засгийн гүн хямралын нөхцөлд төр баригч элит нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэх эрхэм дээд зорилгын төлөө иргэний болон улс төрийн эрхийг зайлшгүй хязгаарлах ёстой гэж үздэг. Тиймээс харгис бодлого явуулж, сөрөг хүчин, ОНМХ-д дарамт шахалт үзүүлэх явдал огцом нэмэгджээ. Дорнод Африкийн Кени, Танзанид нэг намын тогтолцоо тогтож, харин Угандад Иди Аминий (бүтэн хэргэм цол нь «Эрхэм дээд насан туршийн ерөнхийлөгч, Фельдмаршал Аль-Хаджи Доктор Иди Амин, VC, DSO, MC, Газар дээрх бүх араатан, далай доторх бүх загасны Эзэн, ерөнхийлбөл Африк дахь

Британийн эзэнт гүрнийг, тухайлбал Угандаг Байлдан дагуулагч») цэргийн харгис дэглэм олон жил ноёрхсон юм. Засгийн газрыг шүүмжлэх өчүүхэн төдий оролдлогыг улс үндэстний эсрэг өдөөн хатгалга мэтээр хүлээн авдаг байв. Энэ бүхний үр дүнд ОНМХ нь гүйцэтгэх засаглалын дуулгавартай зарц болж хувирсан байлаа.

Ийм нөхцөлд ОНМХ-ийг цаашид хөгжүүлэх гурван номлол бүрэлджээ. Эхний номлол нь ОНМХ-ийг улс орны хөгжлийг түргэтгэх зорилгоор бүрэн дүүрэн ашиглахыг шаарддаг. Хоёр дахь хувилбараар бол ОНМХ-ийн дэд бүтэц хөгжөөгүй, аж үйлдвэрийн болон соёлын нөөц дутмаг, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүйгээс болж хэвлэлийн эрх чөлөө хэрэгжих боломжгүй, тиймээс мэдээллийн хэрэгслүүд эерэг баримтыг мэдээлж, нийгмийн бодит амьдралын сөрөг үзэгдлүүдийг тусгалгүй орхиж, засгийн газрын үзэл суртал, бодлогыг дэмжих ёстой. Олон ургальч үзлийн хязгаарлаж буйг бичиг үсэгт тайлагдаагүй байдал, хүн амын улс төрийн ухамсар доод төвшинд байгаа, үүнээс улбаалаад мэдээллийн янз бүрийн эх сурвалжууд, ОНМХ дэх эсрэг тэсрэг байр суурь нь нийгэмд үл ойлголцол бий болгож, үндэсний хөгжлийн язгуур зорилгыг биелүүлэхэд саад болно гэж тайлбарладаг. Гурав дахь хувилбар нь эдийн засгийн хөгжлийг хүний хөгжлөөс ангид авч үзэж болохгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх ёстой, иргэд үзэл бодлоо илэрхийлэх, мэтгэлцээнд оролцох эрхээ эдлэх ёстой гэж номлодог¹³.

Гэвч Африкийн орнуудын сэтгүүл зүйн байдал оюун дүгнэлтийн загварууд

даас нэлээдгүй ялгаатай. Зах зээлийн харилцаанд шилжсэн, төрийн хяналт чангарсан нь үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд сөргөөр нөлөөлж байна. Түүнээс гадна Африк тивийн гамшиг болсон ядуурал, авлига, сүйрсэн дэд бүтэц, ажилгүйдэл, банк болон санхүүгийн салбарын дампуурал зэрэг хүчин зүйл сэтгүүл зүй хөгжихөд чөдөр тушаа болж байгаа юм. 1990-ээд оноос хойш Африкийн ОНМХ-ийн тогтолцоонд дорвитой өөрчлөлт гараагүй гэж судлаачид үздэг¹⁴.

Кени, Уганда, Танзани зэрэг Дорнод Африкийн оронд Үндсэн хууль нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан байдаг ч бодит амьдрал дээр гүйцэтгэх засаглал сэтгүүлчдийн аливаа шүүмжлэлт нийтлэл, нэвтрүүлгийг элдвээр хязгаарлахыг зорьдог бөгөөд төрийн тусгаар тогтнолд заналхийлж болзошгүй нийгэм-улс төрийн тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж байна гэж үүнийгээ тайлбарладаг. Угандад Гүтгэлгийн тухай хууль, Төрийн эсрэг ухуулга сурталчилгааны тухай хууль, Төрийн аюулгүй байдлын акт нь Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуулиар олгосон хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласан байдаг. Гүтгэлэгтэй холбоотой хэрэг үүсэхэд нийтлэлийг бичсэн сэтгүүлчээс гадна редактор, хэвлэлийн эзэн, мухлагийн эзэн, жижиглэнгийн борлуулагч нар эрүүгийн хэрэгт татагддаг байна. Тэгэхдээ сонины редакци тухайн сэтгүүлчээс илүү хүнд ялд унадаг. Төрийн албан хаагчдын (тэдний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэгдсэн байсан ч) хувийн амьдралыг дэлгэхийг хуулиар хориглодог. Хэвлэ-

лийн эрх чөлөөг боомилсон дээрх гурван харгис хуульд Угандагийн сэтгүүлчдийн аюулгүй байдлын хороо нэмэлт өөрчлөлт оруулахаар Үндсэн хуулийн цэцэд 1995 онд хандсан ч хоёр жилийн дараа татгалзсан хариу авчээ.

Танзанид үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний гол дайсан болсон Сонины акт нь 1976 оноос хойш засваргүй үйлчилж буй юм. Аль 1940-1950-иад оны үед колоничлогчдын баталсан харгис шинжтэй хуулийн олон заалт уг Актад хэвээр оржээ. Редакциудад тавигдах шаардлагыг Сонины акт тогтоодог бөгөөд тэдгээрийг зөрчвөл мөнгөн торгууль ногдуулах, хорих ял оноох, ОНМХ эрхлэх эрхийг хасах зэрэг шийтгэл хүлээж байдаг. Иймэрхүү агуулгатай хуулиуд Кенид ч үйлчилдэг.

Дорнод Африкийн орнуудад ОНМХ-ийг бүртгэж, зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг нь зохицуулахад төр маш ихээр хутгалдан орсон байдаг. Долгионы цахилгаан соронзон үелзэл нь ард түмний өмч учир түүний нэрийн өмнөөс төрийн эрх барьдаг засгийн газар энэхүү үеэлзлийг хуваарилж, хязгаарлалт тогтоодог гэсэн номлол дээр теле, радио өргөн нэвтрүүлгийн зохицуулалт суурилдаг. Тэгэхдээ зохицуулалтын маш жигтэй арга, хэлбэр ашигладаг. Тухайлбал, Кенийн засгийн газар төрийн бус радио, телевизтэй хувьцаат түншлэл тогтоосон байдаг. Өнөөдрийн байдлаар санхүүгийн ийм харилцаа таван телестанци дээр үйлчилж байна. Харин Кенийн 39 сая иргэний хувьд мэдээллийн гол хэрэгсэл болсон радиог цензурын тусгай хороо хянадаг. Дууг хүртэл агуулга нь засгийн

газрыг шүүмжилсэн өнгө аястай гэж үзвэл цацахыг хориглодог ажээ. Угандагийн ерөнхийлөгч Й.Мусевени засаглал, сэтгүүл зүй түншилж байгааг илэрхийлэхийн тулд ерөнхий редакторуудтай байнга уулзалт-ярилцлага хийдэг. Чухам юу ярьж байгааг сонсголгүйгээр телевизийн эфирээр дүрсийг нь харуулдаг байна. Мусевенигийн засгийн газрыг шүүмжилдэг редакторууд түүнтэй нэг ширээний ард суугаад, инээлдээд хуучилж байгааг харсан үзэгчид ОНМХ-д итгэх итгэлээ алдаж, сэтгүүлчдийг хоёр нүүртэн гэж буруушаадаг ажээ.

Танзанид Үндсэн хууль үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тунхагласан байдаг ч хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжид дурдаагүй байдгаас лицензийн зохицуулалт гэгч чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, засгийн газрыг шүүмжлэхээс зугатасхийдэг ХМХ-д лицензи олгодог, харин шүүмжилдэг бол элдэв шалтгаар лицензи олгохыг хойшлуулдаг байна.

1993 оноос хойш тус улсад төрийн бус цахим ОНМХ-үүд үүсч эхэлжээ (12 теле-, 8 радиостанци). Танзанийн теле-, радио өргөн нэвтрүүлгийн комисс өргөн нэвтрүүлэг цацах эрхийн лицензи олгохоосоо өмнө саналаа илэрхийлэгч нь нийгмийн ашиг тусын тулд үйлчлэх хүсэл зоригтой байгаа эсэхийг нь шалгадаг. Шаардлага хангасанд нь 3 жил хүртэл (радио), 5 жил хүртэл (телевиз) лицензи олгож, өргөн нэвтрүүлэг цацах газар нутгийн дээд хэмжээг тогтоож өгдөг. Энэ нь улс орны талбайн 25 хувь хүртэл газар нутаг юм. Ийм зохицуулалтын үр дүнд хүлээн авагчдын (25 сая радио сонсогч, 3 сая телевиз үзэгч)

ухамсарт 25 хувийн хязгаарлалт үйлчилдэггүй төрийн мэдлийн теле-, радио-компаниуд нөлөөлөх монополь эрхтэй болдог¹⁵.

ОНМХ-д үзүүлдэг дарамт шахалт нь зөвхөн шүүхэд татаж, ял оногдуулахаар бус, мөн импортын цаас, хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тариф, татварын тогтолцоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн лицензи, засгийн газрын реклам нийтлэхийг шаардах, торгууль зэргээр илэрдэг байна.

Гэхдээ Африкийн орнуудын сэтгүүл зүйн өнөөгийн байдлыг нилэнхүйд нь хараар төсөөлж, ойлгох нь ташаа юм. Дэлхий нэг том тосгон болсон учир сансрын теле, радио өргөн нэвтрүүлэг, Интернет-технологи, түүний дотор сонин, сэтгүүлийн цахим хувилбар сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж, хөгжлийн эрчээрээ уламжлалт мэдээллийн хэрэгслүүдийг гүйцэж түрүүлээд байна.

Ишлэл

¹ Михайлов С. А. 2002. Современная зарубежная журналистика: правила и парадоксы. СПб., с. 301.

² Михайлов С. А. 2004. Журналистика Соединённых Штатов Америки. СПб., с. 473.

³ Altschull J. H. 1984. Agents of Power. N. Y.: Longman, p. 301-305.

⁴ Merrill J. 1974. The Imperative of Freedom. N. Y.: Hastings House, p. 85-98.

⁵ Терри Г. Электронные СМИ в США /Лекция, прочитанная на факультете журналистики СПбГУ 15 окт. 1998 г.

⁶ Вартанова Е. Л. 1999. Финская модель на рубеже столетий. Информационное общество и СМИ Финляндии в европейской перспективе. М., с. 287.

⁷ Эйнсли Р. 1971. Пресса в Африке. М., с. 289.

⁸ Шолов В. Н. 1993. Демократизация в зеркале африканской прессы //Журналистика. История и современность. М., с. 82.

⁹ 1999. World Bank Report Summary. Internet Economic Toolkit for African Policy Market.

¹⁰ Ньянгено А. 1994. Пресса Бенина: правовые, этнолингвистические и экономические аспекты развития (нач. 90-х гг.) Автореф. дисс. канд. филологич. наук. М., с. 2-3.

¹¹ Михайлов С. А. Современная зарубежная журналистика, с. 321.

¹² Раджаб А. Ш. 2001. Пресса и власть в странах Восточной Африки (проблемы взаимодействия). Автореф. дисс. канд. политич. наук. СПб., с. 3.

¹³ Там же, с. 10-11.

¹⁴ Михайлов С. А. Современная зарубежная журналистика, с. 326.

¹⁵ Раджаб А. Ш. Указ. соч., с. 15-16.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Абдул Азиз Х. Ежедневная печать Египта (1960-1971 гг.). М. 1976.

2. Беспалова А. Г., Корнилов Е. А., Короченский А. П., Лучинский Ю. В., Станько А. И. История мировой журналистики. Изд. 2-е. Ростов-на-Дону. 2000.

3. Вартанова Е. Л. 1999. Финская модель на рубеже столетий. Информационное общество и СМИ Финляндии в европейской перспективе. М.

4. Виноградова С. М. 1991. Современные западные теории журналистики и проблемы массовой информации в Тропической Африке /Учебное пособие. Часть I, Л.,

5. Ворошилов В. В. Журналистика. СПб. 2001.

6. Михайлов С. А. 2002. Современная зарубежная журналистика: правила и парадоксы. СПб.

7. Михайлов С. А. 2004. Журналистика Соединённых Штатов Америки. СПб.

8. Нечаева И. Ю. 2000. Африканские телекоммуникации накануне XXI века /От книги до Интернета. Журналистика и литература на рубеже нового тысячелетия. М.
9. Ньянгено А. 1994. Пресса Бенина: правовые, этнолингвистические и экономические аспекты развития (нач. 90-х гг.) Автореф. дисс. канд. филологич. наук. М.
10. Раджаб А. Ш. 2001. Пресса и власть в странах Восточной Африки (проблемы взаимодействия). Автореф. дисс. канд. политич. наук. СПб.
11. Эйнсли Р. 1971. Пресса в Африке. М.
12. Зулькафиль М., Чойсамба Ч. Сэтгүүл зүйн түүх. УБ. 2005.
13. Altschull J. H. 1984. Agents of Power. N. Y.: Longman.

14. Merrill J. 1974. The Imperative of Freedom. N. Y.: Hastings House.

15. Milton G. 1983. Mass Communication in Africa. London.

Резюме

В настоящей статье автор подробно излагает современное состояние и особенности развития журналистики стран Европы, США и Африки. Автор рассматривает специфику континентальной журналистики от британской на конкретных примерах функционирования масс-медиа. Также уделяется внимание журналистике стран тропической Африки, которая на современном этапе развития сталкивается с многочисленными трудностями.